



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№167
/380/

2022.09.20

Цаг үе, үйл явдал

“ЦЭРГИЙН ЭМНЭЛГИЙН ТУСГАЙ БЭЛТГЭЛ-2022” БУУХИА ТЭМЦЭЭН ЭХЭЛЛЭЭ



Төрийн болон хууль байгууллагуудын эмнэлгийн дунд зохион байгуулж буй “Цэргийн эмнэлгийн тусгай бэлтгэл-2022” тэмцээний үйл ажиллагаа Хужирбулан хүчний сургалтын төвд боллоо.

цэргийн сахиулах эмч, Ажиллагааны газрын дарга С.Дашзэвэг, Эрүүл мэндийн хэлтсийн дарга Т.Сүхбаатар, Цэргийн төв эмнэлгийн дарга, хурандаа Б.Энх-Од нарын тэргүүтэй бүрэлдэхүүн

Энэхүү нээлтэд Ажиллагааны газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг, Эрүүл мэндийн хэлтсийн дарга хурандаа Т.Сүхбаатар, Цэргийн төв эмнэлгийн дарга, Ерөнхий эмч хурандаа Б.Энх-Од нарын тэргүүтэй удирдлагын оролцов.

Хос тангарагтай эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн багаар ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх, эмнэлгийн шаталсан тусламжийг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх, аливаа цагийн байдалд үүрэг гүйцэтгэх чадварыг дээшлүүлэх зорилготой тус тэмцээнд Зэвсэгт хүчний жанжин штаб, Төрлийн цэргийн

командлал, Хил хамгаалах Ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб, Цэргийн төв эмнэлэг, Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн 16 багийн 96 алба хаагч мэргэжлийн ур чадвар, авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдөх юм.

ҮБХИС-ИЙН ӨВӨЛ СУРГУУЛИЙН БЭЛТГЭЛ АЖИЛТАЙ ТАНИЛЦЛАА



Өнөөдөр Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, бригадын генерал Ж.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсэг ҮБХИС-ийн үйл ажиллагаа, өвөл сургуулийн бэлтгэлжилтийн нөхцөл байдалтай танилцлаа.

ҮБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан сургуулийнхаа өдөр тутмын үйл ажиллагааны талаар танилцуулж цаашдын ажлын төлөвлөгөө болон тулгамдаж буй асуудлуудын талаар илтгэл тавьсан юм.

Ажлын хэсэг ҮБХИС-ийн бүтэц зохион байгуулалт, бие бүрэлдэхүүний өдөр тутмын үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн ёсзүй, хариуцлага, Засгийн газрын хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, өвөлжилтийн бэлтгэлийг хэрхэн хангасан байдалтай танилцаж үнэлэлт, дүгнэлт өглөө.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 17	☁️ 1

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 32	☁️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.415	3.430
EUR 🇪🇺	3.415	3.430
CNY 🇨🇳	486	490
RUB 🇷🇺	53.50	54.50
JPY 🇯🇵	24.20	24.55
KRW 🇰🇷	2.46	2.48

ЗУРХАЙ



2022.09.20 /МЯГМАР ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 18

**НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ
САР
НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ
УЛААН ХУЛГАНА ӨДӨР**

Үс засуулбал:

Нүд бүрэлзэн улцайна.

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.36-19.56

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Төрөхүй

Тус өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол муу. Нохой уливал амгалан сайн болох, тагнай загатнавал дээрэм ирэх, бие татвал аюул болно.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 617,459,775

Эдгэрсэн

Нийт: 597,247,091

Нас барсан

Нийт: 6,531,688

Цаг үе, үйл явдал

“АЛДАР”ЫНХАН 123 МЕДАЛЬ ХҮРТЭЖ ТҮРҮҮЛЛЭЭ



Монголын бүх ард түмний спортын XV их наадмын шигшээ тэмцээн 2022 оны 9 дүгээр сарын 9-18-ны өдрүүдэд болж өндөрлөлөө.

Дөрвөн жилд нэг удаа зохион байгуулагддаг тус наадамд зуны олимпын 20, паралимпын 3, дифилимпын 2 нийт спортын 25 төрлөөр Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэг, Зэвсэгт хүчин болон бусад хууль сахиулах байгууллагуудын спорт хороо, клубүүдээс 4570 орчим тамирчин оролцсон юм. Батлан хамгаалах яамны харьяа Зэвсэгт хүчний “Алдар” спорт хорооны баг тамирчид Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/268 дугаар тушаалын дагуу спортын 13 төрлөөр амжилттай оролцон 56 алт, 38 мөнгө, 29 хүрэл медаль нийт 123 медаль хүртэж тэргүүн байр эзэллээ. Энэ нь тус хамт олны 13 дахь удаагийн түрүү юм.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АВАРГУУД УДАХГҮЙ ТОДОРНО

Зэвсэгт хүчний 2022 оны аварга шалгаруулах тэмцээний нээлт өнөөдөр ҮБХИС-ийн гадаа талбайд хөл бөмбөгийн тэмцээнээр эхэллээ.

Тэмцээн 9 дүгээр сарын 19-29-ний хооронд явагдах бөгөөд хөл бөмбөг, сагсан бөмбөг, гар бөмбөг, рагби гэсэн үндсэн 4 төрлөөр 30 гаруй багийн 1200 гаруй тамирчин оролцож хурд хүч самбаагаа сорих юм.

Тэмцээний нээлтийн үйл ажиллагааны үеэр цэрэгжлийн спортын төрлөөр 1, 2, 3 дугаар зэргийн болзол хангасан тамирчин алба хаагчдыг шагнаж урамшуулав.

Цэрэгжлийн спортын нэгдүгээр зэргээр Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн ахлагч А.Бат-Эрдэнэ, 350 дугаар ангийн ахлагч Б.Мөнхтөр, ахлагч Б.Далайсайхан, ахлагч Ц.Мөнх-Эрдэнэ, дэд мастер цол тэмдгээр Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн ахлагч Б.Балжинням, ахлах ахлагч Б.Бирваа, “Биеийн тамирын алдар” медалиар Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн ахлах ахлагч Б.Ганзаяа, Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн ахлах ахлагч Б.Одмаа нарыг тус тус шагналаа.

Х.УНДАРМАА



ХЭЭРИЙН СУРГАЛТ, ДАДЛАГЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын 2022 оны сургалт, бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу штабын нэгдсэн сургалт, дадлагыг хээрийн байрлалд нийслэл, дүүргүүдийн ЗДТГ-ын Цэргийн штабын офицер, ахлагч нартай 2022 оны 9 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургалтаар Цэргийн штабуудын бүрэлдэхүүний бэлэн байдалд үзлэг хийх, үүрэг гүйцэтгэх боломжийг үнэлэх, заагдсан сэдвүүдийн хүрээнд илтгэл, тооцоо боловсруулах, алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэг, дадлага, чадварыг нэмэгдүүлэх зэрэг олон асуудлыг боловсруулж сургалтаар тавьсан зорилго, зорилтоо биелүүллээ.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ



Батлан хамгаалах яам



Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС



“Соёмбо” сонин



“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.

* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)